



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 23 өдөр

Дугаар А/15

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай Монгол Улсын хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргаар ахлуулсан ажлын хэсэг Дөргөн, Чандмань, Зэрэг, Дарви, Цэцэг, Манхан сумдын ард иргэдтэй уулзаж, өвөлжилтийн нөхцөл байдалтай танилцах зорилгоор ажиллах зардалд 1 031 940 төгрөг, Мо-Эн-Ко ХХКомпанитай 2018 онд хийсэн гэрээний хэрэгжилтийг дүгнэж, цаашдын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэхээр хийсэн уулзалтын арга хэмжээнд 1 330 000 төгрөг, Баян-Өлгий аймгийн Засаг дарга болон удирдлагуудтай бүс нутгийн хөгжлийн хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор хийсэн уулзалтын арга хэмжээний зардалд 202 000 төгрөгийг тус тус зарцуулсугай

2. Дээрх арга хэмжээнүүдэд зарцуулах 2 563 940 төгрөг /Хоёр сая таван зуун жаран гурван мянга есөн зуун дөчин/-ийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн ангилагдаагүй зардлын нөөцөөс гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

02 ЗахИМЖ